



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/97

Пионер толгой

┌ Малчдын чуулга уулзалтын
зардал гаргах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын Нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр засаг, аймаг, орон нутгийг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд хөдөө аж ахуйн салбар, малчдын талаар тусгагдсан бодлого шийдвэрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөх, малчдын санал хүсэлтийг сонсох, арга туршлагыг солилцох, цаашид малчдын талаар авч хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох зорилгоор “Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган”-нд оролцох сумын малчид иргэдийн хоол, унааны зардалд 1,550,000 (Нэг сая таван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 1,550,000 (Нэг сая таван зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.



ДАРГА

Б.ГАНТУЛГА

Сумын Засаг даргын 2023 оны
09 дугаар сарын 20 -ний өдрийн
1997 дугаар захирамжийн хавсралт



Уулзалтын зардлын тооцоо

№	Гүйлгээний утга	Мөнгөн дүн
1	Шатахууны зардалд	1,000,000
2	Хоол хүнсний зардалд	550,000
	Дүн	1,550,000

оОо